

**ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР
ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2016 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2017.07.05

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан байдаг.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийн заалтыг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн 2016 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 68 хуулийн 262 заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 111 хуулийн 376 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн нь хяналтанд авсан нийт хуулийн 44 буюу 64.7 хувь, 204 заалт буюу 77.9 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үлдсэн 67 хуулийн 172 заалтын хэрэгжилтийн мэдээний хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх онуудад бүрэн хэрэгжиж, хяналтнаас хассан хуулийн хэрэгжилтийн мэдээнүүд болно.

Мэдээнээс үзэхэд давхардсан тоогоор 77 хуулийн 170 заалт буюу 45.3 хувь нь хэрэгжсэн, 56 хуулийн 148 заалт буюу 39.4 хувь нь хэрэгжих шатанд байгаа, 5 хуулийн 9 заалт буюу 1.5 хувь нь хэрэгжээгүй, 11 хуулийн 29 заалт буюу 7.8 хувь нь хугацаа болоогүй, 13 хуулийн 17 заалт буюу 4.5 хувь нь үнэлгээгүй, 2 хуулийн 2 заалт буюу 0.5 хувь нь хүчингүй болсон байна.

2.2. Монгол Улсын хуулиар Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 3 хуулийн 14 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар 3 хуулийн 3 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 2 хуулийн 2 заалт 100 хувь хэрэгжсэн, 1 хуулийн 1 заалтын хэрэгжилт мэдээгээр 2016 оны хагас жилийн байдлаар 70 хувийн хэрэгжилттэй гэж ирүүлсэн ч “Үнэлгээгүй ажил” гэж хэрэгжилтийн үнэлгээг зөрүүтэй ирүүлсэн байна. Мөн хяналтад байгаа 2 хуулийн 11 заалт буюу 78.5 хувийн хуулийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	Хууль	Заалт	
	/Давхардсан тоогоор/	Тоо	Хувь
Хяналтанд авсан	3	14	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	3	3	
Үүнээс:			
- Хэрэгжсэн	2	2	14.3
- Хэрэгжээгүй	1	1	7.2
- Хэрэгжилт ирүүлээгүй	2	11	78.5

2.3. Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй

- Ард нийтийн санал асуулгын тухай (*Шинэчилсэн найруулга, 2016.02.05-ны өдөр батлагдсан*) хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.6, 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалт;
- Сонгуулийн тухай (*2015.12.25-ны өдөр батлагдсан*) хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 63 дугаар зүйлийн 63.9, 75 дугаар зүйлийн 75.5, 82 дугаар зүйлийн 82.3, 87 дугаар зүйлийн 87.10, 128 дугаар зүйлийн 128.4, 157 дугаар зүйлийн 157.4 дэх заалтуудын хэрэгжилтийн мэдээг тус тус ирүүлээгүй байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

2016 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын нийт 83 тогтоолын 303 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд, бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын нийт 74 тогтоолын 194 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн бөгөөд 9 тогтоолын 109 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 74 тогтоолын 194 заалтын 98 заалт буюу 50.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 73 заалт буюу 37.6 хувь нь хэрэгжих шатанд, 11 заалт буюу 5.7 хувийн хэрэгжих хугацаа болоогүй, 2 заалт буюу 1.0 хувь хэрэгжээгүй, 10 заалт буюу 5.2 хувь нь үнэлгээгүй ирүүлсэн байна.

3.2. Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын 6 тогтоолын 18 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар 6 тогтоолын 18 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 5 тогтоолын 15 заалт 100 хувь хэрэгжсэн, 3 тогтоолын 3 заалтын хэрэгжилт 50-70 хувьтай байна.

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 93 тогтоолын 505 заалтыг хяналтанд авснаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2016 оны жилийн эцсийн байдлаар 55 тогтоолын 272 заалтын буюу хяналтанд авсан нийт заалтын 53.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 55 тогтоолын 272 заалтаас 42 тогтоолын 121 заалт буюу 44.4 хувь нь хэрэгжсэн, 37 тогтоолын 92 заалт буюу 33.8 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 8 заалт буюу 2.9 хувь нь хэрэгжээгүй, 7 тогтоолын 40 заалт буюу 14.7 хувь нь хэрэгжих хугацаа болгоогүй бол 8 тогтоолын 11 заалт буюу 4.04 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

4.2. Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд Төрийн байгуулалтын байнгын хорооны 6 тогтоолын 20 заалтыг 2016 оны жилийн эцсийн байдлаар бүртгэж хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд тус Байнгын хорооны хяналтад авагдсан тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээг ирүүлээгүй болно.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд дэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар бүрэн биелэсэн Монгол Улсын 2 хуулийн 2 заалт, Улсын Их Хурлын 5 тогтоолын 15 заалтын мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна. Үүнд:

Хууль тогтоомжийн нэр	Хууль тогтоомжийн тоо	Заалтын тоо
Монгол Улсын хууль	2	2
Улсын Их Хурлын тогтоол	5	15

ЗУРГАА. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ САНАЛ

1/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийж, үнэлээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулан тайлбарлаагүй, хэрэгжилтийн явцыг тоочих байдлаар нэгтгэн ирүүлсэн байна.

2/Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

3/Мэдээллийн сангийн хяналтаас хасах саналтай Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн нийт 6 хуудас жагсаалтыг хавсаргав.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	Сонгуулийн тухай хууль 2015.12.25	61.20. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуульд нийцүүлэн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, давхардлыг шалгах, сонгогч шилжих журмыг батлан мөрдүүлнэ.	Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын даргын 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн “Журам батлах тухай” А/187 дугаар тушаалаар “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, давхардлыг шалгах, сонгогч шилжих журам”-ыг баталсан.
2	Ард нийтийн санал асуулгын тухай /Шинэчилсэн найруулга/ 2016.02.05	3.6. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах, тоолох, зохион байгуулахтай холбогдсон журмыг энэ хууль болон Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн сонгуулийн төв байгууллага болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан Сонгуулийн тухай хуульд гадаад улсад байгаа иргэдээс санал авах, тоолох, зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан ба уг хуульд 2016 оны 5 дугаар сарын 05-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр гадаад улсад байгаа иргэд Улсын Их Хурлын сонгуульд оролцож санал өгөх боломжгүй, харин Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй.
Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нийт 2 хуулийн 2 заалтыг хяналтаас хасах санал ирүүлсэн байна.			

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН
ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p>Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</p> <p align="center">2012.09.14 №32</p>	<p>1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах;</p> <p>2.2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 19.4.4 дэх заалт, 19.6.3 дахь заалтын хэрэгжилтийн бэлтгэл ажлыг хангах, гүйцэтгэх;</p> <p>3.Энэ тогтоолын биелэлтийг 2012 оны 12 дугаар сарын 31-нээс өмнө Монгол Улсын Их Хуралд танилцуулж мэдээлэх</p>	<p>Орон нутгийн сонгуулийн үйл ажиллагааны хэрэгжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж амжилттай зохион байгуулж сонгуулийн дүнг хуулийн хугацаанд Улсын Их Хуралд танилцуулсан.</p>
2	<p>Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай</p> <p align="center">2013.02.08 №:23</p>	<p>2.1.Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2013 оны 2 дугаар улирлын эхний хагаст, салбарын хөгжлийн төсөл, хөтөлбөрийг 2013 онд тус тус багтаан боловсруулж, батлан хэрэгжүүлэх;</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг батлуулсан. Тус баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор батлагдсан.</p> <p>Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан.</p> <p>Төлөвлөгөөний дагуу 2017 онд болон 2017 оноос эхлэн барьж байгуулах, барилга байгууламж, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг нийслэлийн эдийн</p>

			<p>засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, нийслэлийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан болно.</p> <p>“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө”-ний төслийг Засгийн газрын 2016.03.28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 174 дүгээр тогтоолоор батлуулсан.</p>
		<p>2.3 нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийг хангах, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд аймаг, сум, хот, тосгоныг хөгжүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийг тодорхойлж Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах;</p>	<p>Засгийн газрын 2016.01.12-ны өдрийн 35 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2030 оны төлөвлөгөө”-ний 6.1-д “2017-2030 онд Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулна” гэж заасан.</p> <p>Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тусгагдсан 14 дагуул, хаяа хот, тосгодын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/482 дугаар захирамжийн дагуу Багахангай дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг “Эрхэт констракшн” ХХК боловсруулж НИТХ-ын 2015 оны 28/16 дугаар тогтоолоор батлуулж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/482 дугаар захирамжийн дагуу “Биокомбинат, Туул-Шувуун фабрик орчмыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлыг “Арт констракшн” ХХК гүйцэтгэсэн. НИТХ-ын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 198 дугаар тогтоолоор батлагдсан.</p>
		<p>2.4.Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын</p>	<p>Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг</p>

		<p>баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах 25.4 их наяд төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн улсын төсвөөс санхүүжүүлэх хэсгийг жил бүрийн улсын төсөв, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд тусган шийдвэрлүүлж байх, бусад хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан өргөн мэдүүлэх;</p>	<p>хэрэгжүүлэхэд шаардагдах 25.4 их наяд төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэх хэсгийг жил бүрийн улсын төсөв, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд тусган шийдвэрлүүлсэн.</p> <p>Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд АХБ, ЕОХБ, МУ-ын Засгийн газрын санхүүжилтээр “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр УИХ-ын тогтоол гарсны дагуу зээлийн гэрээ байгуулан хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.</p> <p>Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгөнөөс нийслэлийн төсөвт дараах байдлаар тусган хэрэгжүүлж ажилласан.</p> <p>1.Нийслэлийн нийгэм, эдийн засгийн 2013 оны зорилтод 1.1 тэрбум төгрөгийг тусгуулан холбогдох зураг төслийн ажлуудыг боловсруулж батлуулсан. Үүнд: НЗД-ын 2013 оны А/482 дугаартай захирамжийн дагуу “Налайх дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г 148.5 сая төгрөгөөр “Нью Урбанизм” ХХК боловсруулсан.</p> <p>Тус ажлын эцсийн тайланд улсын экспертизээр магадлал хийлгэж баталгаажуулсан бөгөөд НИТХ-ын 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 28/14 дугаар тогтоолоор батлагдсан.</p> <p>-“Багахангай дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г 132.0 сая төгрөгөөр “Эрхэт констракшн” ХХК боловсруулсан.</p> <p>Тус ажлын эцсийн тайланд улсын экспертизээр магадлал хийлгэж баталгаажуулсан бөгөөд НИТХ-ын 2015 оны 28/16 дугаар тогтоолоор батлагдсан.</p>
--	--	---	---

3	<p>Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай 2016.08.30 №:27</p>	<p>2/ энэ тогтоолын 1-д заасан зардлыг дараахь байдлаар сонгуулийн ерөнхий хорооны төсөвт нэгтгэн төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай: 1/сонгуулийн ерөнхий хорооны батлагдсан төсвөөс 6,6 тэрбум төгрөгийг; 2/Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн батлагдсан зардлаас хэмнэгдсэн төсвөөс 1,5 тэрбум төгрөгийг; 3/Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахаар аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваарилсан зардлаас 5.8 тэрбум төгрөгийг.</p>	<p>Тогтоолд заасны дагуу 2016 оны төсвийн тодотголоор Сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлыг орон нутгийн төсвийн суурь зардлаас бууруулж, Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцад шилжүүлж, орон нутгийн сонгуулийн зардлыг нийт 13,958.4 сая төгрөгөөр тусган батлуулсан.</p>
4	<p>Юмжаагийн Цэдэнбал агсны алдар гавьяаг мөнхжүүлж, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2016.08.30 №:29</p>	<p>1.Юмжаагийн Цэдэнбал агсны мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай: 1/Юмжаагийн Цэдэнбал агсны амьдрал, үйл ажиллагааны талаархи түүхэн үнэнийг ард түмэнд тайлбарлан таниулж, алдар гавьяаг нь мөнхжүүлэх арга хэмжээ авах;</p>	<p>2016 оны 9 дүгээр сарын 15-нд “Алдар гавьяаны замнал” үзэсгэлэнг Монголын Үндэсний төв музейд нээв. Ойн арга хэмжээний хүрээнд Ц.Жамбалсүрэн “Монгол цэргийн нэрт зүтгэлтэн Маршал Ю.Цэдэнбал”, Д.Төрбат “Маршалын нууц товчоон, номуудын нээлтийн ажиллагааг Тусгаар тогтнолын ордонд, 2016 оны 9 дүгээр сарын 16-нд Маршал Ю.Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан Баярын хурал, хүндэтгэлийн концертыг Соёлын төв өргөөнд 2016 оны 9 дүгээр сарын 17-нд Маршал Ю.Цэдэнбалын шарилд хүндэтгэл үзүүлж, цэцэг өргөх ёслолын үйл ажиллагааг Алтан-Өлгийд, Маршал Ю.Цэдэнбалын хөшөөнд хүндэтгэл үзүүлж, цэцэг өргөх ёслолын ажиллагааг Ю.Цэдэнбалын нэрэмжит талбайд тус тус зохион байгуулав. Мөн Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчдийн Бүх нийтийн хүндэтгэлийн тоглолт Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан бол</p>

			Маршал Ю.Цэдэнбалын 100 жилийн ойд зориулсан бөхийн барилдаан Монгол бөхийн өргөөнд тус тус зохион байгуулагдсан болно.
		2.ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг баталж, зохион байгуулах комисс байгуулан ажиллуулах;	Ой тэмдэглэх тухай Засгийн газрын 2016 оны 33 дугаар тогтоолоор арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн.
		4.ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд судалж шийдвэрлэх.	Монгол Улсын төр, нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардалд шаардагдах 602.3 /зургаан зуун хоёр сая гурван зуун мянган/ сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр зааснаас гүйцэтгэлээр нийт 495.1 сая төгрөгийг бүрэн санхүүжүүлсэн.
5	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2016.09.07 №:38	2/энэ тогтоолын 1-д заасан хүүхдийн мөнгийг олгохдоо өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаж, хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргасан нийт өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд сар бүр 20 мянган төгрөгийг дор дурдсан нөхцөлөөр олгохыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай: 2.1.2016 оны 1-6 дугаар саруудад хүүхэд бүрд;	Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр 20.0 мянган төгрөгийг бэлэн болон бэлэн бусаар олгож байна. Хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 60.0 хувьд нь буюу Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 502.567 гэсэн босго онооноос доогуур зорилтот өрхийн 660.0 мянган хүүхдэд бэлэн мөнгөөр олгож байна.
Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нийт 5 тогтоолын 13 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэнд хяналт шинжилгээ хийгээд 5 тогтоолын 11 заалтыг хасах саналтай байна.			